



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 11 өдөр

Дугаар А/199

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” –ын 10.3.4, 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутаг хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Улиастай багийн Уурагтын даваа, Хүрдэтийн хошуу, Шавартын хэжлэг, Амгалангийн богч, Дунд, Ар жалгын амын зам, засварын ажлын гүйцэтгэлийг тус тус хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Орхонтуул (Засаг даргын орлогч)

Гишүүд: Д.Дэмиддагва (6 дугаар багийн Засаг дарга)


Ж.Батмөнх (Байгаль хамгаалагч)

Г.Бүд (Засаг даргын Тамгын газрын нярав)

Д.Ганзориг (сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч)

2. Захиалагчийн техникийн тодорхойлолтод заасан шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан нөхцөлд хүлээн авч, акт үйлдэн ажлын гүйцэтгэл, үр дүнг тайлагнахыг ажлын хэсэг (Н.Орхонтуул)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН